# Таныг хамгаалах дүрмүүд

## Либерец аймагт гадаадын иргэний аюулгүй амьдрал



Liberecký kraj

Монгол

# Либерец аймгийн талаар



## Та үүнийг мэдэх үү...

**... Либерец аймаг нь далайн түвшинээс ямар өндөрт байдаг вэ?** Хамгийн өндөр уул нь **КОТЕЛ** гэж нэртэй. Энэ уул Чех улсын 10 дахь том уулын нэг, далайн түвшинээс 1435 м?

… Либерец аймаг нь **Чех Улсад хамгийн их ой модтой**?

… тус аймагт **2680 км гаруй явган аялалын замтай** Еизерийн цанын баазтай. Цана, тэшүүрээр гулгах **180 км замтай** Чех улсад цанын гүйлтийн хамгийн алдартай газруудтай?

**... Маахын нуур** 284 га газар эзлэдэг **Чех Улсад томоороо** зургаад орно,өмнөд Чех улсын хамгийн том нуруудаас гадна?

… Тус аймагт хэд хэдэн том газар нутаг хамардаг, **Крконоше үндэсний парк** (ЧУ-ын хамгийн эртний) Дархан цаазат газар 5, үндэсний байгалийн хөшөө дурсгал 8, байгалийн нөөц бүхий газар 36, байгалийн дурсгалт газар 68, хамгаалалттай байгалийн парк 3 тус тус байдаг?

… 171 км$^2$ талбайтай Ральско хот нь Чех улсын хамгийн том газар нутагтай хотын захиргаанд харьяалагддаг?

… аймагт **Үндэсний соёлын дурсгалт газар бүхий** 12 барилгатай?

… Либерец аймаг **хамгийн хуучин ЗОО парктай** хуучин Чехословакийн нутаг дэвсгэр дээр (1904 онд нээгдсэн)?

… Соёл, спортын арга хэмжээнд эдгээр зүйлс ордог: Липа Музик, Бенаткын шөнө, Кристалын хөндий, **Еизерин тавь?**

Liberecký kraj



**Газар нутаг:**

**3 163 km²**

Прага хотын дараа Чех Улсдаа хоёрдахь аймагт ордог, Чех улсын газар нутгын 4% эзэлдэг

**Хүн ам:**

**443 690**

(2020-1-1нд)

**Хотын захиргааны тоо**

**215**

үүнээс 39 хот ба 4 хотхон (4 дүүрэг, үүнээс 10 хотын захиргаа өргөтгөсөн эрх мэдэлтэй)

**Хүн амын нягтаршил**

**140,3**

км² ногдох хүн амаараа Прага хотоос гадна аймгуудын тавдугаарт ордог.

# Таныг хамгаалах, дүрмүүд

## гадаадын иргэний аюулгүй амьдрал Либерец аймагт

# ГАРЧИГ


| | | |
|---|---|---|
| 01 | Шуурхай дуудлагын дугаар | 4 |
| 02 | Гадаадын иргэдийн эрх үүрэг | 5 |
| 03 | Хөдөлмөр эрхлэлт | 8 |
| 04 | Байр орон сууц | 12 |
| 05 | Сургууль | 14 |
| 06 | Чөлөөт цаг | 17 |
| 07 | Аюулгүй байдал | 19 |
| 08 | Эрүүл мэнд | 23 |
| 09 | Зорчих | 25 |
| 10 | Чех Улсад оршин суух зарчим | 27 |
| 11 | Чухал холбоо–Либерец сум | 28 |
| 12 | Чухал холбоо–Ческа Липа сум | 31 |
| 13 | Чухал холбоо–Яблонице сум | 34 |
| 14 | Чухал холбоо–Семиле сум | 37 |

# Угтах үг

Энэ товхимолыг бүх орны гадаадын иргэнд зориулсан. Европын Холбооны орнуудаас ирсэн гадаадын иргэд, Европын Холбооны бус орны гадаадын иргэдийн эрх үүрэг. Энэ бүхэн таны Чех Улсад оршин суух ангиллаас хамаарна.

Оршин суух ангилалтай танилцахыг зөвлөж байна. Үүнээс эрх үүрэг үүснэ. Уг товхимолд ЕХ-ны гадаадын иргэд, ЕХ-ны бусад орны гадаадын иргэд гэж хуваагдана. Үүнд ерөнхий журам, мэдээллийг өгнө.Тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ холбогдох байгууллагуудтай холбоо барих хэрэгтэй. Товхимолын ард тэдгээрийн жагсаалт байгаа.

**Танд зөвлөгөө хэрэгтэй юу?**

**Либерец аймгийн гадаад иргэдийн интеграцчилалыг дэмжих төв (CPIC) эсвэл Гадаадын иргэдийн интеграцчилалын төвөөс нийгэмийн болон хууль зүйн эрхийн зөвөлгөөг үнэгүй авч болно.**



**Оршин суухтай холбогдолтой асуудал (оршин суух хугацааг сунгах, оршин суух зорилгыг өөрчлөх г.м) талаархи мэдээллийг Дотоод хэргийн яамны вэбсайтаас авах боломжтой**

***https://www.mvcr.cz/clanek/sluzby-pro-verejnost-informace-pro-cizince-informace-pro-cizince.aspx***

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

## 01

# Шуурхай дуудлагын дугаар

| Түргэн тусламж | Гал унтраах анги | Цагдаа | Европын яаралтай тусламж |
|---|---|---|---|
| 155 | 150 | 158 | 112 |

**Хэрэв танд тусламж хэрэгтэй бол шууд энэ дугаар уруу утасд. Эдгээр дугаар уруу залгах нь үнэ төлбөргүй байдаг.**

**Буруу ашигласан тохиолдолд торгууль ногдуулах болно. Шугамууд 24 цагийн турш ажилладаг.**

***«Аврах» программыг татах >***



## Ямар үндсэн мэдээлэл өгөх вэ?

Ярилцлага авахад өгөх мэдээлэл:

**ХЭН дуудсан**
**ХААНА байна**
**ЮУ болсон**

# 02 Гадаадын иргэний эрх, үүрэг

## Үндсэн үүрэг

**ЕХ-ны орны иргэд**

**Ажлын 15 хоногийн дотор** ДХЯ-д нэр, овог, хувийн байдал (гэрлэлт, салалт, бэлэвсэн), гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэх дэх өгөгдөл өөрчлөгдсөнийг мэдэгдэнэ.

**Ажлын30 хоногийн дотор** Чех Улсад оршин суух газрын харьяа гадаадын цагдаагийн газар 30 ба түүнээс дээш хоног байхыг мэдэгдэнэ. Хэрэв дотуур байрны эзэн тань таны хаягийг мэдэгдсэн бол та мэдэгдэх шаардлагагүй.

**ЕХ-ны бус орны иргэд**

**Ажлын 3 хоногийн дотор** ДХЯ-д нэр, овог, хувийн байдал (гэрлэлт, салалт, бэлэвсэн), гадаад паспорт эсвэл оршин суух үнэмлэх дэх өгөгдөл өөрчлөгдсөнийг заавал мэдэгдэнэ.

**Ажлын 3 хоногийн дотор** ирсэн даруй Чех Улсад оршин суух газрын харьяа гадаадын цагдаагийн газар бүртгүүлэнэ.Хэрэв дотуур байрны Эзэн тань таны хаягийг мэдээлсэн бол та үүнийг мэдэгдэх шаардлагагүй.

## ЕХ болон ЕХ –ны бус орны иргэдийн үүрэг

- Ажлын 30 хоногийн дотор оршин суух хаяг нь 180 хоногоос дээш байх бол өөрчлөлтийг мэдэгдэнэ.
- Ажлын 3 хоног дотор оршин суух зөвшөөрлийн картыг алдсан, гээсэн, гэмтсэн, хулгайлагдсан тухай мэдэгдэнэ.
- Аялалын бичиг баримт (паспорт) алдагдсан, хулгайлагдсан тухай Чехийн цагдаагийн газарт нэн даруй мэдэгдэх.
- Чех улсад оршин суух хууль ёсны нотлох баримтыг өөртөө авч явах.
- Чех улсын хууль тогтоомжийг мэдэж даган мөрдөх
- Таны үйл ажиллагаа явуулж буй хотын, захирамжыг мэддэг байх (жишээлбэл олон нийтийн газар архи уухыг хориглоно).
- Баримт бичгийг Чех хэл рүү орчуулсан байх ёстой. Орчуулгыг Чехийн шүүхийн зөвшөөрөлтэй албан эрх бүхий орчуулагч хийх ёстой. (дугуй тамгатай).



**Шүүхийн орчуулагчдын бүртгэлийг вэбсайт дээр онлайнаар эсвэл үүнийг QR код ашиглан харах боломжтой:**

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

## Гадаадын иргэний эрх

- Хүний үндсэн эрх, эрх чөлөө хувийн эрх чөлөө, хүний нэр төрийг хадгалах, албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүчирхийллээс хамгаалах эрх.
- Ялгаварлан гадуурхахаас хамгаалах эрх хөдөлмөрийн тэгш бус нөхцөл.
- Хувь хүнийг эрхийг хамгаалах.
- Эрх, үүргийг баталгаажуулах. Хэрэв та эрх, үүргээ сайн мэдэхгүй байгаа бол ашгийн бус байгууллага эсвэл CPIC -тэй холбоо бариарай.

## ЕХ –ны бус иргэд хууль бусаар оршин суух

Чех улсад нэвтрэхийн тулд та богино болон урт хугацааны визтэй, урт хугацааны эсвэл байнгын оршин суух эрхтэй байх ёстой (эсвэл оршин суух эрхийг авахын тулд D VR шошготой. Сонгогдсон орнуудын иргэд Чех улсад визгүй зорчиж болно. Хууль бус цагаачлал гэдэг нь дээр дурдсан шалтгаангүйгээр Чех улсад нэвтрэх явдал юм.

**Бид олон улсын хамгаалалтыг (орогнол, туслах хамгаалалт) оршин суух жагсаалтад санаатайгаар оруулдаггүй, учир нь өөрийн гэсэн тодорхой дүрэм журамтай**

Хууль бус шилжилт хөдөлгөөн нь оршин суух зорилгоо биелүүлээгүй явдал юм.

Жишээлбэл: Гадаадын иргэн ажил хийхээр ирээд ажлаа зогсоож, бизнесээ эхлэх ёсгүй. Оршин суух зорилгоо биелүүлэхгүй байх нь байнга тохиолддог асуудал бөгөөд үүнээс болж Чех улсад гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгодог

Тодорхой нөхцөлд Чех улсад байх зорилгоо өөрчлөх хүсэлт гаргах боломжтой. Яаж хийхийг мэдэхгүй байна уу? Үнэгүй зөвлөгөө өгөх байгууллага эсвэл Дотоод хэргийн яамны орогнол, шилжилт хөдөлгөөний бодлогын хэлтэстэй холбоо бариарай. Харилцагчдыг товхимолын төгсгөлөөс олж болно.

## Хүчин төгөлдөр бичиг баримтгүй, хуурамч бичиг баримттай, оршин суух зөвшөөрөлгүй гадаадын иргэн Чех улсад хууль бусаар оршин суухад цагдаа дараах байдлаар ажиллана:

- Ихдээ 48 цагийн турш түр хорих.
- Хувийн мэдээллийг баталгаажуулах, хуруун хээ авна.
- Цагдаагийн байгууллага албадан гаргах тухай шийдвэр гаргана (Чех улсын нутаг дэвсгэрээс) эсвэл иргэдийг саатуулах байранд шилжүүлэх (харуул хамгаалалттай байлгах)



## Танд зөвлөгөө хэрэгтэй байна уу? Дараах байгууллагуудтай холбоо бариарай (товхимолын ард байгаа)

**Либерец аймгийн гадаадын иргэдийн орогнол, шилжин суурьшилтын бодлогын газар**

**ЧУ-ын гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар**

**Либерец аймгийн гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв**

**Гадаадын иргэдийн интеграцчилалын төв**

# 03 Хөдөлмөр эрхлэлт

Чех улсад гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг гадаадын иргэдийн оршин суух тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг. Ажилтаны эрх үүргийг хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг. Хэрэв та хөдөлмөрийн гэрээ эсвэл түүний заалтуудын аль нэгийг ойлгохгүй байгаа бол гэрээг орчуулж өгөх эсвэл Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төвтэй, эсвэл гадаадын иргэдийг интеграцчилах төвтай холбоо бариарай.

***Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бүх асуудлыг бичгээр хийх ёстой. Аман гэрээ нь нотлогоогүй бөгөөд Чех улсын хууль тогтоомж зөвшөөрдөггүй. Баримт бичгийн нэг хувийг ажилтан, нөгөө хувийг ажил олгогч хүлээн авна.***

## Хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндсэн ойлголтууд

| | |
|---|---|
| **Ажиллах цаг** | **Долоо хоногт ихдээ 40цаг** |
| **Илүү цаг ажиллах** | **Долоо хоногт ихдээ 8 цаг, жилд 150 цаг (харилцан тохиролцсоны дагуу илүү зохицуулах боломжтой)** |
| **Ээлжийн амралт** | **Жилд багадаа 4 долоо хоног (ажил олгогч илүү өгч болно. Харин дутуу байж болохгүй)** |
| **Туршилтын хугацаа** | **0–3 сар,удирдлагуудын хувьд дээд тал нь 6 сар** |
| **Гэрээ цуцлах хугацаа** | **Хуулийн дагуу 2 сар, харилцан тохирч гэрээг өөрчлөх боломжтой** |
| **Цалингийн доод хэмжээ** | **2020 онд 14600чех крон(татвар, хураамжийн өмнө)** |

## Албадан нэмэлт төлбөр

| | |
|---|---|
| **Шөнийн цагаар ажиллах (22:00–06:00)** | **Цагийн дундаж орлогын 10 %** |
| **Илүү цагаар ажиллахад** | **Цагийн дундаж орлогын 25 %** |
| **Баярын өдрүүдээр ажиллахад** | **Цагийн дундаж орлогын 100 %** |
| **Хагас,бүтэн сайн амралтын өдөр ажиллахад** | **Цагийн дундаж орлогын 10 %** |



**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газрын тогтоолоор өөрчилж болно. Та эндээс олж болно:**

***https://www.mpsv.cz/minimalni-mzda***

*QR кодоор линкийг татаж авах заавар товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

# Хөдөлмөрийн гэрээ, түүний шаардлага

- Хөдөлмөрийн гэрээ хугацаатай эсвэл хугацаагүй гэж байна. Хөдөлмөрийн харилцаа нь тохиролцсон хугацаа дууссаны дараа дуусгавар болно. Хөдөлмөрийн гэрээг 2 удаа сунгаж болно, дараа нь хугацаагүй гэрээ болно. (нэг хөдөлмөрийн харилцаа = нэг хөдөлмөрийн гэрээ, + хоёр сунгалт).

- Ажилд орсон өдрөөс эхлэн туршилтын хугацаа ихэвчлэн 3 сар байдаг. Туршилтын хугацаанд ажил олгогч шалтгаангүйгээр ажлаа цуцлах шийдвэр гаргаж болно.

- Хөдөлмөрийн гэрээг цуцлах хугацаа нь 2 сар байдаг. Уг хугацаанд ажиллах ёстой. Хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай бичигээр мэдэгдэнэ. Гарах хугацааг дараа сарын 1- ээс тоолоно.

- Хэрэв та өвчний улмаас ажлын чадвараа алдах өвчний чөлөө авах эрхтэй (акт). Эмч ажил олгогчид руу таныг өвчтөй гэсэн хуудас илгээн дараа нь түүнийг цахимаар хаана.

- Хэрэв ажлын цагаар эмчид үзүүлэх шаардлагатай бол ажил олгогч заавал зөвшөөрөх ёстой. Дараа нь үзүүлсэн гэсэн баримт авчирна. Ер нь бол ажлын бус цагаар эмчид үзүүлэх ёстой.

- Цалингийн хуудсыг ажил олгогчоос хүсч болно. Сар бүр өгөх үүрэгтэй. Ажил олгогч таныг ажилаар томилон явуулсан тохиолдолд төлбөрийн баримт өгнө. Хуулийн дагуу хоол хүнс, замын зардал байрны төлбөрийг авах эрхтэй.



**Томилолтын хоолны хэмжээний тооцоо. Жил бүр өөрчлөгдөж болох учир эндээс олж болно:**

***https://www.mfcr.cz/cs/legislativa/cestovni-nahrady***

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

# Хөдөлмөрийн гэрээг цуцлах аргууд

| | Туршилтын хугацаанд цуцлах | Ажил ологчийн талаас цуцлах | Ажилтаны талаас цуцлах | Цуцлах хугацаа |
|---|---|---|---|---|
| Хэзээ | Ажилд орсон өдрөөс 3 сарын дотор (хэрэв хөдөлмөрийн гэрээнд байгаа бол) | Хэзээд шалтгаан нь хуулийн заалтаар | Хэзээ ч | Хэзээ ч |
| Гарах шалтгааныг дурьдах | Үгүй | Байна | Үгүй | Үгүй |

| | Туршилтын хугацаанд цуцлах | Ажил олгогчийн талаас цуцлах | Ажилтаны талаас цуцлах | Цуцлах хугацаа |
|---|---|---|---|---|
| Цуцлах хугацаа | байхгүй | Хөдөлмөрийн гэрээний дагуу голцуу 2 сараар дараа сарын эхний өдрөөс тоолоно | Хөдөлмөрийн гэрээний дагуу голцуу 2 сараар дараа сарын эхний өдрөөс тоолоно | Үгүй,Ажил олгогч ажилтантай тохироно хөдөлмөрийн гэрээг цуцлах хугацааг хүлээн зөвшөөрөх |
| Гэнэт халагдсаны тэтгэмж | Үгүй | Тийм тодорхой нөхцөл байх | Үгүй | Үгүй |

Жирэмсэн эмэгтэйчүүд, жирэмсэний болон хүүхэд асрах чөлөөтэй хүмүүсийн хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгоход тусгай хамгаалалтай.

Хөдөлмөрийн харилцаа нь хугацаатай гэрээ дууссаны дараа (тодорхой өдрөөс хойших гэрээ) цуцлагдаж болно. Тогтмол хугацааны гэрээний хугацаа дуусахаас өмнө ажил олгогчтой сунгах талаар тохиролцох хэрэгтэй.

***Ойлгоогүй баримт бичиг дээр гарын үсэг бүү зур! Тухайн ажилтаны хөдөлмөрийн харилцааг цуцлах (мөн ажилтаны туршилтын хугацаанд цуцлах замаар) эсвэл хөдөлмөрийн гэрээгээ цуцлах тухай гэрээнд гарын үсэг зурснаар гадаадын иргэд Европын Холбооноос бус орнууд зарим тохиолдолд Чех улсад оршин суух зөвшөөрлөө алддаг!***

***Ажлаас халагдсаны дараа ажил хийсэн тооцооны баримт бичиг (ажлын тайлан) мөн тэтгэврийн даатгалын бүртгэлийн хуудасыг ажил олгогчоос ав***

## ЕХ –ны бус гадаадын иргэд, ажилчдын карт

Чех улсад ажиллах, оршин суух зөвшөөрөлийн дээд хэмжээ 2 жил хүчинтэй бөгөөд сунгах боломжтой. Ажилтаны карт нь танд тодорхой ажлын байрны, тодорхой ажил олгогч дээр ажиллах боломжийг олгодог. Та ажил олгогчийг өөрчлөх эсвэл өөр ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээгээр ажилд орох эрхтэй.

**Ажил олгогч нь гадаадын иргэдийг ажиллуулахыг зөвшөөрч буйгаа тэмдэглэх ёстой.**






**Хэрэв та ажил өөрчлөлт, өөр ажлын талаар мэдээлээгүй бол хууль бусаар ажиллаж байна! Шинэ ажил тань хөдөлмөрийн албаны бүртгэлд байх ёстой. Эндээс харна уу:**

***https://www.uradprace.cz/web/cz/volna-mista-v-cr***

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

# ЕХ орны гадаадын иргэд

Чех улсад та болон танай гэр бүлийн гишүүд хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй. Та Чех улсын иргэдтэй адил эрх үүрэгтэй. Таны ажил олгогч таныг ажилд орсон тухайгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд мэдээллэнэ.

**Жишээлбэл, та энэ сайт дээр ажил хайж болно:**
***www.uradprace.cz***
***www.jobs.cz***
***www.prace.cz***

# Ажил дээрх үүрэг хариуцлага

- Та ажил олгогчийн дотоод журмыг дагаж мөрдөх үүрэгтэй
- Та ажлын байран дахь ослоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Хэрэв осол гарсан бол та ажил олгогчдод нэн даруй мэдэгдэх ёстой. Бичигээр баталгаажуулахыг хүснэ үү.
- Хэрэв таны ажилд хамгаалалтын хэрэгсэл шаардлагатай бол түүнийг өмсөх үүрэгтэй.

# Хууль бус ажил гүйцэтгэх

- ЕХ -ны бус гадаадын иргэний хувьд та олгосон хөдөлмөрийн картгүй / ажиллах зөвшөөрөлгүй ажилладаг.
- ЕХ -ны орноос ирсэн гадаадын иргэнд олгосон хөдөлмөрийн картгүй, ажиллах зөвшөөрлийн дагуу ажилладаг бөгөөд өөрчлөлтийн талаар мэдэгдээгүй (өөр ажил олгогч эсвэл өөр ажлын байранд ажиллаж байгаа).
- ЕХ -ны бус гадаадын иргэний хувьд та оршин суух зөвшөөрөлгүй ажилладаг.
- Танд бүх зөвшөөрөл байгаа боловч хөдөлмөрийн харилцаа байхгүй болно жишээ нь: „турших ажиллах“.
- Шварц систем– Хөдөлмөрийн гэрээний оронд та хөдөлмөр гүйцэтгэх гэрээтэй агентлаг, зуучлалын гэрээтэй гэх мэт. Гэхдээ та үнэхээр ажилтны үүрэг гүйцэтгэдэг (удирдах албан тушаалтан бол ажил олгогч, ажлыг томилж, хянадаг ажил нь ажил олгогчийн ажлын байранд тодорхой цагт явагддаг).

Хууль бус ажил хийхэд ажил олгогч танд эрүүл мэндийн болон нийгмийн даатгал төлдөггүй. Эрүүл мэндийн асуудал гарсан тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг өөрөө төлөх шаардлагатай болно. Нийгмийн даатгал төлөгдөөгүй гэдэг нь хууль бусаар ажиллаж байх хугацаандаа тэтгэврийн даатгалд ажилласан хугацааг хамруулах эрхгүй бөгөөд энэ нь тэтгэврийн доод хэмжээнээс доогуур гэсэн үг юм. Хууль бус ажил хийхэд **100 000 крон** хүртэл торгууль төлөх бөгөөд хүчинтэй ажилчдын картыг сунгахгүй. Ажил олгогч **10 000 000 крон** хүртэлх торгууль төлүүлэнэ.

***Танд зөвлөгөө хэрэгтэй байна уу? Дараах байгууллагуудтай холбоо бариарай (товхимолын ард): Либерец аймгийн ОАМП, Устий над Лабем мужын Либерец аймгийн хөдөлмөр хяналтын газар, гадаадын иргэдийг интеграцчилалыг дэмжих төв, Либерец аймгийн гадаадын интеграцын төв.***

# 04 Байр,орон сууц

Чех улсад орон сууц авах олон сонголтууд байдаг. Энэ хэсэгт орон сууцны талаархи үндсэн ойлголтуудыг тайлбарлах болно. Орон сууцны талаархи бүх бичиг баримтыг бичгээр өгөх ёстой! Оршин суух зөвшөөрлөө сунгахын тулд танд байрны гэрээ хэрэгтэй болно.

## Ерөнхий зарчим

1. Шуудангийн хайрцаг, хонхон дээр овог, нэрээ бичиж мөн тогтмол шалгаж байх.
2. Хэрэв та нүүж байгаа бол шинэ хаягаа Орогнол, Цагаачлалын бодлогын хэлтэс, /гадаадын иргэдийн цагдаагийн газар/ эсвэл бусад байгууллагад (банк, утасны оператор, сэтгүүлийн захиалга гэх мэт) мэдэгдэх ёстой.
3. Байрны дотоод дүрмүүдтэй танилцаж, тэдгээрийг дагаж мөрдөөрэй (жишээлбэл, нийтийн эзэмшлийн талбай цэвэрлэх).
4. Шөнө оройн 22:00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл чимээ шуугиан гаргахгүй байгаарай.

## Хамгийн түгээмэл нэр томъёо

**Хувийн орон сууц**
Орон сууц худалдаж авах тохиолдолд бүх гэрээг бичгээр бичиж, үл хөдлөх хөрөнгийн кадастрын, өмчлөгчийн хуулбарыг бүрдүүлэх шаардлагатай. Хадгалсан мөнгөө өөрийн орон сууцанд зарцуулах, эсвэл зардлынхаа хэсгийг банкнаас барьцаалан зээлдүүлэх замаар санхүүжүүлэх боломжтой. Ипотекийн зээлийн хувьд энэ нь урт хугацаат зээл, төлбөр юм. Ипотекийн зээлийг бүрэн төлөх хүртэл та үл хөдлөх хөрөнгийн банкинд баталгаа өгөх болно.

**Түрээсийн орон сууц**
Үл хөдлөх хөрөнгийн эзэн бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглах эрхийг танд үлдээх болно. Энэ нь тодорхой эсвэл тодорхой бус хугацаагаар байж болно. Түрээс гэдэг нь орон сууц түрээслэх дүн юм. Эрчим хүчний төлбөр, хог хаягдал цуглуулах гэх мэт бусад үйлчилгээг гэрээнд тусгаж болно. Хэрэв тэд гэрээнд ороогүй бол та эдгээр үйлчилгээний төлбөрийг хэрхэн төлөхөө эзэмшигчтэйгээ тохиролцох ёстой.

**Дэд түрээсийн орон сууц**
Үл хөдлөх хөрөнгийн эзэн үүнийг түрээслүүлсэн бөгөөд тэрээр танд бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр түрээслүүлэнэ. Түрээсийн орон сууцны нэгэн адил гэрээ нь тодорхой эсвэл тодорхой бус хугацаатай байж болно. Түрээс, эрчим хүчний төлбөрийн систем нь түрээсийн орон сууцтай адил юм

**Орон сууцны гэрээ ба дотуур байр**
Энэ нь богино хугацааны орон сууц юм. Байрны эзэн танд өрөө түрээслүүлнэ, та дотуур байрны нийтлэг газруудтай танилцах боломжтой. Та гэрээний заалтууд болон байрны журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

**Барьцаа**
Орон сууц түрээслэх гэрээнд гарын үсэг зурахаас өмнө буцааж төлж болох барьцаа төлбөрийг танаас хүсч болно. Энэ нь 1-3 сарын түрээсийн төлбөр юм Хэрэв та түрээсийн мөнгөө төлж чадахгүй, ирээдүйд орон сууцанд хохирол учруулбал түрээслэгч эдгээр зардлыг нөхөхийн тулд барьцаа ашиглана. Түрээсийн хугацаа дууссаны дараа эзэмшигч нь барьцаа хөрөнгөө буцааж өгөх ёстой (хэрэв тэр мөнгөний тодорхой хувийг шалтгаантай

төлөхөд ашиглаагүй бол) хохирол, түрээсийг төлөөгүй гэх мэт. Барьцаа нь түрээсийн заавал байх ёстой хэсэг биш бөгөөд үүнийг огт тохиролцох шаардлагагүй байж болно. Хэрэв та барьцаа төлбөрөө төлж байгаа бол төлбөрийн баримтаа гаргаж өгнө үү.

## Орон сууц хаанаас хайх вэ

Таны эхний алхам ажлын газар, найз нөхөд, хамт ажилладаг хүмүүсээс асууж холбоо тогтоохыг хичээгээрэй. Facebook группээс ч хайж болно. Жишээлбэл; Либерец орон сууц, түрээслэх орон сууц Ческа Липагийн хайлтын системд оруулана уу … Хэрэв та ийм байдлаар орон сууц олохгүй бол үл хөдлөх хөрөнгийн агентлагууд эсвэл интернет хайлтын системийн үйлчилгээг ашиглаж болно (***www.sreality.cz***, ***www.bezrealitky.cz***, ***www.bazos.cz***, …). Хэрэв та үл хөдлөх хөрөнгийн агентлагийн үйлчилгээг ашиглаж байгаа бол түрээсийн төлбөрийг төлөх болно.

## Орон сууцны төрөл

Зар сурталчилгаанаас та орон сууцны зориулалт ба тоонуудын хослолыг олж болно. Эхний тоо нь өрөөний тоог илэрхийлнэ. Гал тогоо нь тусдаа өрөө (**+1** гэж тэмдэглэсэн) эсвэл өрөөний нэг хэсэг (тэмдэглэгдсэн **кк**) байж болно.

**1kk** 1 өрөө,гал тогооны өрөө нь хамт
**1+1** 1 өрөө, гал тогооны өрөө тусдаа
**2kk** 2 өрөө,гал тогооны өрөө нь том өрөө хамт
**2+1** 2 өрөө, гал тогооны өрөө тусдаа



***Танд зөвөлгөө хэрэгтэй байгаа юу? Дараах байгууллагуудтай холбоо бариарай (товхимолын ард ):Либерец аймгийн гадаадын иргэдийн оргнол, шилжин суурьшилтын бодлогын газар, ЧУ-ын гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар, Либерец аймгийн гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв, Гадаадын иргэдийн интеграцчилалын төв.***

# 05 СУРГУУЛЬ

Чех улс нь хүүхэд, насанд хүрэгчдэд зориулсан өргөн хүрээний боловсролын системтэй. Эдгээр нь улсын, хувийн болон сүм хийдийн боловсрол юм.

| | | |
|---|---|---|
| **6 сар – 3 нас** | **Ясли** | **Заавал биш, төлбөртэй** |
| **2–5 нас** | **Цэцэрлэг** | **Заавал биш, тодорхой хэмжээний төлбөртэй** |
| **5–6 нас** | **Цэцэрлэг** | **Заавал, төлбөргүй** |
| **6–15 нас** | **бага сургууль, лицей** | **Заавал, төлбөргүй** |
| **15–19 нас** | **дунд сургууль, лицей, мэргэжлийн сургууль** | **Заавал биш,голцуу төлбөргүй** |
| **19 а дээш нас** | **их, дээд сургууль, мэргэших** | **Заавал биш,голцуу төлбөргүй** |

Заавал явах шаардлагатай боловч цэцэрлэг, бага сургуульд сургуулийн хоолны төлбөрийг төлдөг. Бага сургуульд хүүхэд үдийн хоолонд орох шаардлагагүй. Чөлөөт цагаа өнгөрүүлэх хүүхдүүдэд зориулсан янз бүрийн дугуйлан ихэвчлэн төлбөртэй байдаг.

Сургуулийн хэрэгсэлийг худалдаж авах, аялалын төлбөр, театрт зочлох, цанаар гулгах, усанд сэлэх зэрэг ерөнхий зардлыг тооцох шаардлагатай.

## Боловсрол, чех хэл мэдэхгүй байх

***Чех хэл мэдэхгүй хүүхдүүд дараах тусламжыг авах боломжтой:***

- Бэлтгэл анги
- 2 жил доош ангид орох
- Нэмэлт хичээл заалгах
- Сургуулийн чех хэлний дугуйланд явах
- Сайн дурын хүүхдүүдийг сургах (сайн дурын төв, ашгийн бус байгууллага)
- Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төвийн Чех хэлний сургалт
- Ашгийн бус байгууллагуудын Чех хэлний сургалт



**Хэрэв сургууль нь гадаадын иргэдэд хичээл заах туршлагагүй бол тэдэнд Чех улсын үндэсний сурган хүмүүжүүлэх хүрээлэнгийн ажилтнууд зөвлөгөө өгөх болно.Мэдээллийг эндээс харна уу:**

***www.cizinci.npicr.cz***

*QR кодоор линкийг татаж авах заавкрыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

Бэлтгэл анги нь сургуульд байдаг боловч заавал хамрагдах шаардлагагүй. Энэ нь хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицоход тусалдаг, анхан шатны ур чадвар, сургуулийн ажлын системийг заадаг. Нэгдүгээр ангид орохоос өмнө хүүхдүүд хамрагдах боломжтой. Бэлтгэл ангид шинээр ирсэн хүүхэд чех хэлний анхан шатны мэдлэгийг эзэмшиж, улмаар нэгдүгээр ангид ороход илүү сайн бэлдэх боломжтой болно. Бага сургуулиуд бүгд бэлтгэл ангитай байдаггүй.

Хэрэв хүүхэд сургуульд бэрхшээлтэй тулгарвал (унших, бичих, боловсролын асуудалтай) сургуультай тохиролцсоны дараа сурган хүмүүжүүлэх сэтгэлзүйн зөвлөгөө өгөх боломжтой. Энэ төв нь хүүхэдтэй хэрхэн харьцах талаар эцэг эх, сургуульд зөвлөгөө өгдөг. Хүүхдийг бэлтгэл ангид оруулахаас өмнө сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвд заавал очих шаардлагатай.

Хэрэв таны хүүхэд сургууль дээрээ ямар нэгэн асуудалтай байгаа бол жишээ нь хэл ойлгохгүй байх эсвэл өөр асуудал байвал багштайгаа холбоо барихаас бүү эргэлзээрэй. Багш нар эцэг эхчүүдтэй уулзахыг эрхэмлэдэг бөгөөд таны сонирхлыг үнэлэх болно. Сургуулиуд хүүхдийн сурлага, зан байдлын талаар эцэг эх, багш нарын уулзалтыг тогтмол хийдэг. Багш нь сурагчдын суралцах үйл явдлын талаар танд мэдээллэх болно. Хэрэв танд орчуулагтай уулзалт хэрэгтэй бол Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төвтэй холбоо бариарай. Сургуулиас Чех улсын Үндэсний сурган хүмүүжүүлэх хүрээлэнгээр дамжуулан орчуулга хийх боломжтой. Орчуулга үнэгүй.

***Та сургуулийн дүрмийн дагуу хүүхдийн хичээлд анхаарах ёстой. Хүүхдээ сургуульд сурч байгаа эсэхийг заавал шалгаарай.Хүүхэд сургуульд хамрагдахгүй байх нь эцэг эхийн буруу, зарим тохиолдолд гэмт хэрэг болно.***

Хотын цагдаагийн ажилтан (цагдаа) сургуулийн цагаар гадаа байгаа хүүхдийн хувийн мэдээллийг баталгаажуулах эрхтэй. Дараа нь мэдүүлэгийг бичгээр OSPOD- хүүхдүүдийн нийгэм, хууль эрх зүйн хамгаалалын байгууллага уруу илгээдэг. Дахин давтахгүйн тулд сургуультай хамтран уулздаг. Хүүхэд сургуульд явахгүй байгаа тохиолдолд сургууль таныг энэ байгуулагтай хамтран уулзахыг шаардана. Та шалтгааныг арилгах хэрэгтэй. Асуудал, түүнийг шийдвэрлэхэд туслана.

Чөлөөт цагаараа хүүхдүүд янз бүрийн сургалтанд хамрагдах боломжтой. Чөлөөт цагаа өнгөрүүлэх үйл ажиллагааг сургууль, хүүхэд, залуучуудын төв, чөлөөт цагаа өнгөрүүлэх төвүүд эсвэл янз бүрийн сонирхолын дугуйлангууд зохион байгуулдаг. Амралтын үеэр хүүхдүүд зусланд эсвэл хотын захаар (зөвхөн өдрийн цагаар ажилладаг) зугаалгананд оролцох боломжтой. Амралт, зугаа цэнгэлийн газарууд ихэвчлэн төлбөртэй байдаг



# Хүүхдийн нийгмийн болон эрх зүйн хамгаалалт (OSPOD)

Та дараахь асуудлаар зөвлөгөө өгөх зорилгоор OSPOD -ийн ажилтантай холбоо барьж болно. Жишээ нь эцэг эх нь тусдаа эсвэл салсан тохиолдолд хүүхдийн нөхцөл байдалд тохирсон шийвдэр гаргаж өгөх. Асрамжийн мөнгийг төлүүлэх, хүүхдийн боловсролын асуудалыг зохицуулах гэх мэт. Гэр бүл салалтыг хууль ёсны дагуу салах нөхцөл байдлыг тохируулах тохиолдолд OSPOD -ийг хүүхдийн асран хамгаалагчаар томилж болно. Шүүх хуралдааны явцад тэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хувьд хүүхдийг төлөөлж, түүний ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд эцсийн хандлага эцэг эхийн асран хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах, асрамжийн хэмжээ, магадгүй эцэг эхтэйгээ хүүхэдтэйгээ хэрхэн харьцах талаар санал болгодог. Цаашилбал, OSPOD -ийг өмчийн асуудлаар хүүхдийн асран хамгаалагчаар томилж болно. Жишээлбэл эцэг эхийн нэг нь хүүхдийнхээ эд хөрөнгийг зарахыг хүсдэг, нөгөө тал нь хүсэхгүй байх гэх мэт.

Хэрэв сургууль, хөршүүд эсвэл бусад иргэд сургуульд заавал хамрагдахгүй бусад иргэд хэнч хүүхдийн хүчирхийлэл, хүүхдэд хайхрамжгүй хандвал OSPOD -ийн ажилтнууд тантай холбоо барин мэдүүлэх хэрэгтэй. Та хамтран боломжийн шийдвэрийг хайж олохыг эрмэлзэх хэрэгтэй. Уулзахаас зайлсхийхгүй байх, хамтран ажиллах, нийтлэг уулзалт хайх нөхцөл байдлыг тайвшруулж, шийдвэрлэх алхамуудыг хийх. Энэ ажилчдын гол зорилго бол гэр бүлд туслах явдал юм.

OSPOD нь эцэг эх, хүүхдүүдэд боловсролын арга хэмжээ авч, зэмлэх, хүүхдийн хүмүүжилд хяналт тавих, эцэг эх, хүүхдүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх мэргэжлийн байгууллагад хандахыг зааж өгч болно. Цаашилбал, OSPOD нь хүүхдийг гэр бүлээс нь түр байршуулах тухай шүүхэд өргөдөл гаргаж болно.



**Хүүхдийн нийгэм, хууль ёсны хамгаалалтын байгууллага нь ихэвчлэн хотын захиргааны байгууллагуудын нэг хэсэг юм. Эндээс харж болно:**

***www.ospod.cz***

*QR кодоор линкийг татаж авах заавры товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

# Гадаадад эзэмшсэн боловсрол хүлээн зөвшөөрөх

Хэрэв та эх орондоо их дээд сургууль төгссөн бол Чех улсад хүлээн зөвшөөрүүлэх боломжтой. Үүний тулд таньд төгсөлтийн гэрчилгээний албан ёсны баталгаажуулсан хуулбар, суралцах хугацаанд судлах хичээлийн жагсаалт, түүний дотор үнэлгээ шаардлагатай болно. Энэ хоёр бичиг баримтыг Чех хэлээр орчуулахад албан ёсоор хүлээн зөвшөөрсөн орчуулагч Чех хэл рүү орчуулах ёстой (дугуй тамга тэмдэгтэй). Үүнтэй ижил төстэй чиглэлээр ажилладаг их сургууль таны өргөдлийг үнэлэх бөгөөд энэ нь таны боловсролыг хэсэгчлэн зөвшөөрөх эсвэл огт хүлээн зөвшөөрөхгүй байж болно. Дүйцүүлэх зөвшөөрөлын өргөдөл нь төлбөртэй.

***Танд зөвлөгөө хэрэгтэй байна уу? Дараах байгууллагуудтай холбоо бариарай (товхимолын ард бий):***

- ***Либерец аймаг бүс нутгийн захиргаа***
- ***Либерец аймгийн -Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төв***
- ***Гадаадын иргэдийн интеграцчилалын төв***
- ***F POINT z.s.***

# **06** Чөлөөт цаг

**Либерец аймагт амралт чөлөөт цагаа өнгөрөөх сайхан боломжууд бий. Эдгээр нь төлбөртэй болон төлбөргүй үйл ажиллагаа явуулдаг.**

**Байгалийн үзэсгэлэнт газрууд болон аялалын сонголтуудын талаархи мэдээллийг олж авах боломжтой:**

***https://www.kudyznudy.cz/objevte-liberecky-kraj***

**Аялалд эсвэл спортоор явахыг хүсч буй хотоо бичээд хайгаарай, та хүссэн зүйлээ олох болно.**

## Либерец нь Чех улсын хамгийн их ой модтой бүс юм



**Чех улс, Либерец мужууд дугуйн замын өргөн сүлжээг бий болгосон. Хэрэв та унадаг дугуйтай бол доорх линкээс дугуйн замыг олох боломжтой. Та газар нутгийн байршил, аялахыг хүсч буй газрынхаа дагуу хайлт хийх боломжтой.**

**Эндээс харна уу:**

***http://cyklotrasy.info/index.php?stranka=oblasti***

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

Либерец муж бол явган аялал хийхэд тохиромжтой газар юм. Чехийн жуулчдын клуб аялал жуулчлалын маршрутын тэмдэг дээр удаан хугацаагаар анхаарсан. Эхлэх цэгээ оруулсны дараа та маршрутаа эндээс төлөвлөж болно:

*www.trasy.kct.cz*

Маршрутыг гурван судал эсвэл сумаар тэмдэглэсэн байдаг Хоёр цагаан хооронд шар, ногоон, цэнхэр эсвэл улаан тууз байдаг.



Чөлөөт цагаа спортын талбай, кино театр, театр болон бусад байгууллагад үзэх боломжтой. Та спортын газруудын жагсаалтыг хотуудын вэбсайт эсвэл вэбсайтаас олж болно www.mapy.cz дараа нь „Спортын газар“ эсвэл Sport v okolí – www.sportvokoli.cz. Товхимолын төгсгөлд спортын газруудын холбоос байгаа.

Театр, кино театр болон бусад соёлын арга хэмжээний хөтөлбөрийг хотын вэбсайтуу дээрээс нь үзэх боломжтой:

*https://www.informuji.cz*

Либерец нь өөрийн нутаг дэвсгэр дээр баталгаажсан таван аялал жуулчлалын бүстэй үүгээрээ идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажилладаг.

*https://kultura.kraj-lbc.cz/page414/marketingove-turisticke-oblasti-libereckeho-kraje*

Дэлгэрэнгүй мэдээллийг вэбсайтаас авах боломжтой– Cestou necestou:

*https://www.liberecky-kraj.cz*

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

# 07 Аюулгүй байдал

***Чех улсад эх орондоо хэрэглэж байсан аюулгүй байдлын бусад арга хэмжээ, дүрэм журмыг хэрэгжүүлж болно. Та Чех улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.*** *Аюулгүй байдлын арга хэмжээний үндсэн тоймыг доороос уншина уу.*

## Автомашин жолоодох

**Авто машин жолоодох ерөнхий зарчим:**

- Жолооны ард ядарч сульдахаас болгоомжил, урт удаан аялалд тогтмол завсарлага хий!
- Замын хөдөлгөөний зөрчил, гэмт хэргийг оноо ашиглан бүртгэдэг. Хэрэв та 1 жилийн хугацаанд 12 торгуулийн оноо авбал жолоодох эрхээ алдах болно. Та хүсэлт гаргаад 1 жилийн дараа жолоодох эрхээ буцааж авах боломжтой.



**Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан гэмт хэрэг, гэмт хэргийн тоймыг энд оруулав:**

***https://www.tymbezpecnosti.cz/stranky/138***

**Чех улсад 18 нас хүрсэн жолооны эрхтэй хүн машин жолоодох боломжтой.Тээврийн хэлтсүүд танай улсаас жолооны үнэмлэхээ хэрхэн хүлээн зөвшөөрөх талаар зөвлөгөө өгөх болно. Хэрэв та өөрийн улсаас жолооны үнэмлэхгүй бол жолооны сургуультай холбоо бариарай. Сургалт төлбөртэй тул та жолооны сургуулийн жагсаалтыг эндээс харна уу:**

***https://www.vsechny-autoskoly.cz/autoskoly***

*QR кодоор линкийг татаж авах зааврыг товхимолын арын хэсгээс авах боломжтой.*

- ***Жолоо барихад Чех улсад согтууруулах ундааны хэмжээ нойл, хэрэглэхийг огт зөвшөөрдөггүй!*** Жолоо барихаасаа өмнө архи уусан эсэхийг цагдаа шалгах эрхтэй. Хэрэв та тестээс татгалзвал энэ нь зөрчил болно (торгууль, 7 оноо нэмэгдэж, жолоо барих эрх хасах).
- Мансууруулах бодис хэрэглэсний дараа тээврийн хэрэгсэл жолоодох боломжгүй. Цагдаа таниас шинжилгээ өгөхийг шаардана.
- Жолоо барихдаа жолооны үнэмлэх, бичиг баримттай байх ёстой, тээврийн хэрэгслийн даатгал, техникийн карт.



## Явган хүний хөдөлгөөн

- Явган явахдаа явган хүний замыг ашиглаарай. Явган хүний зам байхгүй бол замын зүүн талд явах.
- Явган хүний гарц дээр тээврийн хэрэгсэл хоёр талдаа явахыг хүлээ. Болгоомжтой байгаарай, үргэлж сайн хараарай.
- Харанхуйд алсаас муу харагдах үед явахдаа цацруулагч элемент бүхий зүйл өмсөх буюу ашиглах. Энэхүү үүрэг хариуцлага нь нийтийн гэрэлтүүлгийн хүрээнээс гадуур явахад хамаарна.

## Гэмт хэрэг, зөрчил

Чехийн хууль тогтоомж, орон нутгийн захирамжийг зөрчих нь гэмт хэрэг, эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох болно. Хууль тогтоомж нь нарийн төвөгтэй нөхцөл байдал эсвэл тухайн хүний гэмт хэргийн өнгөрсөн үеийг үнэлдэг тул аль нь гэмт хэрэг, аль нь эрүүгийн гэмт хэрэг болохыг тодорхой хуваах боломжгүй юм.

ЕХ-ны бус орноос ирсэн гадаадын иргэдийн хувьд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн нь Чех улсад цаашид оршин суухад ихээхэн нөлөө үзүүлж магадгүй юм. Хэрэв та санаатай гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдвол таны ажилтаны картыг хүчингүй болгоно. Үүнтэй төстэй дүрмүүд бусад оршин суух нөхцөлд хамаарна!

## ЧУ-ын цагдаагийн газар, хотын цагдаагийн байгууллага

Чех улсын цагдаагийн газрын үүрэг бол нийтийн хэв журам сахиулах, хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах болон эд хөрөнгө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэнэ.

Үр дүнтэй ажиллахын тулд тэд хэд хэдэн эрх мэдэлтэй байдаг. Үүнд:

- Өөрийгөө хэн болохыг нотлох.
- Өөртөө болон бусдад аюултай, бусад иргэнийг хэл амаар болон бусад байдлаар гомдоосон, эд хөрөнгийг бохирдуулсан, гэмтээсэн хүнийг саатуулах. Саатуулах нь гэмт хэрэгт холбогдсон байна.
- Тээврийн хэрэгслийг зогсоож, шалгаж үзэх.
- Жолоочоос архи, мансууруулах бодис байгаа эсэхийг шалгах тодруулах.
- Гэр бүлийн хүчирхийлэлийн үед цагдаагийн ажилтан түрэмгийлэгч, хүчирхийлэгчийг 10 хоногийн турш гэрээс нь тусгаарлаж болно.

Хотын цагдаа нь зөвхөн хотын захиргаанд ажилладаг. Түүний үндсэн үүргүүдэд хүн, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулах, дагаж мөрдөх байдлыг хянах зэрэг орно. Иргэний зэрэгцэн орших дүрмүүд жишээлбэл шөнийн амгалан тайван байдлыг алдагдуулах, журмыг дагаж мөрдөх болон хотын дүрэм сахих. (жишээлбэл журам тогтоосон газарт уухыг хориглох).

## Хүний наймаа, хөдөлмөрийн мөлжлөг

Хүний наймааны зорилго нь хөдөлмөр, бэлгийн мөлжлөг, албадан гэрлэлт юм. Хүмүүс ихэвчлэн хүний наймаанд өртдөг бэлгийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, барилга, гэрийн ажил (хүүхэд асрах, өндөр настнуудын асрах, гэр цэвэрлэх). Хүний наймаанд эрэгтэй, эмэгтэй, хүүхдүүд нэрвэгддэг. Чех улсад энэ үйлдэл нь хууль ёсны бус хүлээн зөвшөөрөгдөхгүй юм! Хөдөлмөрийн мөлжлөг нь хүний наймааны хамгийн түгээмэл шинж тэмдэг юм.

- Та Чех улсад ирэхээсээ өмнө зөвшөөрсөн ажлаасаа өөр ажил хийж байгаа.
- Ажил олгогч таны паспорт эсвэл бусад бичиг баримтыг авах.
- Тэд танд заналхийлэх, таныг ажлынхаа талаар дарамт шахалт үзүүлэх эсвэл бие махбодийн болон сэтгэцийн хүчирхийлэлд өртөх.
- Та урт хугацаагаар ажиллах. Та ээлжийн амралт авах эрхгүй байх.
